



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

Ганбаатар ЦЭВЭЭНДОЛГОР

**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТЭД АСРАН ХАЛАМЖЛАХ АЖЛЫН  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ХЭМЖИХ НЬ**

Шинжлэх ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

УЛААНБААТАР ХОТ

2021



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

Ганбаатар ЦЭВЭЭНДОЛГОР

**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТЭД АСРАН ХАЛАМЖЛАХ АЖЛЫН  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ХЭМЖИХ НЬ**

Мэргэжлийн индекс:Е 03110101

Шинжлэх ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

Удирдагч: Б.Отгонтөгс/профессор/...../

Шүүмжлэгч: ...../..... /...../

УЛААНБААТАР ХОТ

2021

# **ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ХУУДАС**

© 2021

ГАНБААТАР овогтой ЦЭВЭЭНДОЛГОР

## **ТАЛАРХАЛ**

Энэхүү судалгааны ажлыг бичих явцад бүхий л талаар зөвлөж, удирдан чиглүүлсэн удирдагч Б.Отгонтөгс профессор, судалгааны өгөгдлийг боловсруулахад тусалсан ҮСХ-ны Нийгмийн статистикийн хэлтсийн дарга С.Тодгэрэлд, судалгааны ажлыг хийхэд бүхий л талаар тусалж дэмжсэн гэр бүлийнхэндээ гүн талархал илэрхийлье.

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ЦАС - Цаг ашиглалтын судалгаа

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

ILO - International labor organization

АХС - Ажиллах хүчний судалгаа

ӨОЗНС - Өрхийн орлого зарлагын нэгдсэн судалгаа

ӨНЭЗС - Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа

АНУ- Америкийн нэгдсэн улс

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛ**

Хүснэгт.1 Ажиллах хүчинд оролцдог эсэх, гэрлэлтийн байдлаар

Хүснэгт.2 16 хүртэлх насны хамт амьдардаг хүүхдийн тоо, байршлаар

Хүснэгт.3 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн  
пробит загварын үр дүн

Хүснэгт.4 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн  
пробитын ахиу нөлөө

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг.1 Ажиллах хүчний оролцоо

Зураг.2 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, насны ангиллаар

Зураг.3 Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн насны ангилал

Зураг.4 Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд байршлаар

Зураг.5 Боловсролын байдал, байршлаар

Зураг.6 Өрхийн гишүүдийн тоо, давтамжаар

Зураг.7 Долоо хоногийн хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг болон ажлын 1 өдөрт  
хүүхэд асрахад зарцуулж буй хугацааны хамаарал

## **ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

- Хавсралт.1 Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал
- Хавсралт.2 Хетерокедаст байдал шалгах тестийн үр дүн
- Хавсралт.3 Мультиколлинеар байдал шалгах тестийн үр дүн
- Хавсралт.4 Хувьсагчдын тайлбар
- Хавсралт.5 Тоон өгөгдлийн шинж чанар
- Хавсралт.6 Тоон өгөгдлийн шинж чанар / Гэр хороололд амьдардаг эмэгтэйчүүд /
- Хавсралт.7 Тоон өгөгдлийн шинж чанар / Орон сууцанд амьдардаг эмэгтэйчүүд /
- Хавсралт.8 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман регрессийн үр дүн

## **СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ**

Манай улсын эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсаар байгаа бөгөөд үүнд маш олон хүчин зүйлс нөлөөлж байна. Энэхүү судалгаагаар гэр бүлийн гишүүдийг асран халамжлах ажил нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд хэрхэн нөлөө үзүүлдгийг тодорхойлохыг зорин хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн судалгааны ажлуудад ихэвчлэн ашигладаг пробит загвараар үнэлгээгээ хийлээ. “Цаг ашиглалтын судалгаа”-ны мэдээллийг тоон өгөгдөлөө болгон ашигласан бөгөөд энэхүү судалгаа нь өдрийн тэмдэглэлийн аргаар мэдээллээ цуглуулдаг ба манай улсад 2007 оноос хойш хийгдэж байна. Одоогийн байдлаар 2011, 2015, 2019 он гэсэн дөрвөн удаагийн мэдээллийг цуглуулсан байгаа бөгөөд өөрийн ажилдаа 2019 оны тоон өгөгдлийг ашигласан. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг үнэлэх гэж байгаа тул нийт түүврээс насны хязгаар зааж 15-64 насны 4,290 эмэгтэйн мэдээллийг ялган авч загвараа үнэлсэн. Судалгааны үр дүнгээс харвал бакалаврын боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд ажиллах хүчинд оролцох магадлал нь түүнээс бага боловсролтой эмэгтэйчүүдтэй харьцуулахад (пробитын ахиу нөлөө) 10.5 хувиар өндөр гэж үнэлэгджээ. Эмэгтэйчүүдийн хүүхэд асрах цаг нэгээр нэмэгдэхэд ажиллах хүчинд оролцох магадлал нь 6.2 хувиар, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах цаг нэгээр нэмэгдэхэд 7.0 хувиар буурдаг ба энэхүү үнэлгээ нь харгалзан 1% болон 5 %-ийн түвшинд ач холбогдолтой байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд 0-2 насны хүүхэд бол хөдөлмөр эрхлэх магадлал нь үүнээс дээш насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 6.5 хувиар бага байна.

## **ГАРЧИГ**

|                                                         |           |
|---------------------------------------------------------|-----------|
| <b>1. УДИРТГАЛ.....</b>                                 | <b>1</b>  |
| <b>2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТОЙМ .....</b> | <b>3</b>  |
| <b>3. СУДЛАГДСАН БАЙДАЛ.....</b>                        | <b>5</b>  |
| <b>4. ЭМПИРИК АРГАЗҮЙ.....</b>                          | <b>8</b>  |
| <b>5. ТООН ӨГӨГДӨЛ.....</b>                             | <b>10</b> |
| <b>6. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....</b>                        | <b>16</b> |
| <b>7. ДҮГНЭЛТ .....</b>                                 | <b>20</b> |
| <b>НОМЗҮЙ .....</b>                                     | <b>21</b> |
| <b>ХАВСРАЛТ .....</b>                                   | <b>22</b> |

## 1. УДИРТГАЛ

Улс орнуудын хувьд хүн амын хөдөлмөр эрхлэлт нь маш чухал ойлголт төдийгүй үүнтэй тухайн эдийн засгийн хөдөлмөрийн нөөц, ажиллах хүчний оролцоо, ажилгүйдэл зэрэг ойлголтууд салшгүй холбоотой байдаг. Хөдөлмөр эрхлэлтэд макро, микро хүчин зүйлс болон хувь хүний шийдвэр гаргалтууд зэрэг нь нөлөө үзүүлдэг бөгөөд эдгээрийг судлах нь хөдөлмөрийн эдийн засгийн гол зорилго нь юм. Хүн амын хөдөлмөр эрхлэлтэд нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн талаар олон төрлийн судалгаанууд хийгдсэн байдаг ба цаашид ч хийгдсээр байх хуучрахгүй сэдэв билээ.

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд манай улсын ажиллах хүчний оролцоо буурсаар байгаа бөгөөд тэр дундаа эмэгтэйчүүдийн оролцоо илүү буурсаар байна. Тиймээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд гарч байгаа энэхүү өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар судлах нь зүйн хэрэг юм. Одоогийн байдлаар манай улсад нийт ажиллах хүчний оролцоонд болон эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд нөлөө үзүүлж буй зүйлсийг судалсан хэд хэдэн судалгааны ажлууд хийгдсэн байгаа бөгөөд энэхүү судалгааны ажлаараа би эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын<sup>1</sup> үзүүлж буй нөлөөг хэмжих болно.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ILO)-ын тодорхойлолтоор асран халамжлах ажил гэдэг нь хэн нэгэн хүн өөр бусад нэг буюу хэд хэдэн хүнийг бие бялдар, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, хөгжлийн хэрэгцээг хангахын тулд асран халамжлахыг хэлнэ гэжээ. Уг судалгааны ажилдаа асран халамжлах ажлыг доорх байдлаар авч үзнэ.

- Хүүхэд асрах
- Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах
- Өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрах / дэлгэрэнгүйг Хавсралт.1-ээс үзнэ үү/

Эмпирик судалгааны ажлуудаас харвал цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх цаг болон хүүхэд асрах цаг хоёрын хоорондын сөрөг хамаарал нь эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдэд илүү өндөр байна (Bittman, 2004; Sayer et al., 2004a; Craig, 2006a). Манай улсын хувьд үндэсний онцлог, соёл зэргээс шалтгаалан цалин хөлсгүй хөдөлмөр буюу хэн нэгнийг асран

---

<sup>1</sup> Care work

халамжлах болон гэрийн ажлыг ихэвчлэн эмэгтэйчүүд хийдэг гэсэн ойлголттой байдаг. Тиймээс асран халамжлах ажил нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд нөлөө үзүүлдэг байж болох юм. Харин олон түвшний онол, дүн шинжилгээнээс үзэхэд эмэгтэйчүүдийн бүтэн цагийн ажил эрхлэлт өндөр, төсвийн санхүүжилтээр хүүхэд асрах үйлчилгээ их хийгддэг, хүүхэд төрүүлсний дараах эхийн амралт нь богино, хүйсийн эрх тэгш байдлыг хангадаг улс орнуудад эмэгтэйчүүд цалин хөлсгүй ажил буюу гэрийн болон хүүхэд асрах ажлыг бага хийж эрэгтэйчүүд илүү гэрийн ажлыг хийх хандлага ажиглагдаж байна гэжээ. (Cooke & Baxter 2010; Treas & Drobnic 2010).

Судалгааны зорилго: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажил нь нөлөө үзүүлдэг эсэхийг тоон мэдээлэл болон үнэлгээний аргуудыг ашиглан шалгах болно.

Судалгааны зорилт:

- Энэ чиглэлээр өмнө нь хийгдсэн гадаад болон дотоодын судалгааны ажлуудтай танилцах,
- Судалгааны тоон өгөгдөлд анхан шатны боловсруулалт хийх,
- Тоон мэдээлэл дээрээ үндэслэн үнэлгээ хийх,
- Дүгнэлт, санал гаргах


Уг судалгааны ажил нь нэгдүгээрт манай улсын хувьд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөө үзүүлж буй шинэ хүчин зүйлийг судалж байгаагаараа, хоёрдугаарт өмнө нь судалгаануудад ашиглагдаж байгаагүй тоон өгөгдөл буюу “Цаг ашиглалтын судалгаа”(ЦАС)-ны мэдээллийг ашиглаж байгаагаараа шинэлэг ажил юм.

Энэхүү судалгааны ажил нь нийт долоон бүлэгтэй бөгөөд дараагийн хэсэгт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тойм байдлыг харуулна. Гуравдугаар бүлэгт сэдвийн судлагдсан байдал, дөрөвдүгээрт онол аргазүй, тавдугаар бүлэгт судалгааны тоон өгөгдлийг тайлбарлах бол зургадугаар хэсэгт үнэлгээний үр дүн, эцсийн бүлэгт дүгнэлтээ танилцуулах болно.

## 2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТОЙМ

Ажиллах хүчний оролцооны түвшин гэдэг нь хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхэлж буй болон идэвхтэй ажил хайж буй хүн амын хувь юм. Энэ хувь хэмжээ нь бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд бэлэн байгаа хөдөлмөрийн нөөцийн харьцангуй хэмжээг илэрхийлдэг тул хөдөлмөрийн зах зээлийн чухал хэмжүүр юм. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2006 оноос хойш тасралтгүй буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2012 он болон 2017 онд хоёр удаа өссөн дүр зурагтай байна. Хоёр удаа өссөн энэ онд манай улсын эдийн засаг өсөлттэй байсан ба гадаадын хөрөнгө оруулалт өндөр байсан онууд байгаа бөгөөд эдийн засаг сайжирч байсан тул үүнийгээ дагаад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн гэж үзэж байна. 2019 оны байдлаар манай улсын эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 53.4 хувь буюу эрэгтэйчүүдийн оролцооны түвшнээс даруй 15 хувиар бага байна. 2019 онд 15-аас дээш насны 2.1 сая хөдөлмөрийн насны хүн ам байгаа бөгөөд үүний 47 хувь буюу 998 мянга нь эрэгтэйчүүд бол үлдсэн 53 хувь буюу 1.1 сая нь эмэгтэйчүүд байжээ.

Зураг.1 Ажиллах хүчний оролцоо




Эх сурвалж: ҮСХ

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог ҮСХ-ны насны ангиллаар салган харвал 25-50 насныхан хамгийн өндөр оролцоотой байна. Доорх зурагт ажиллах хүчний оролцоонд 2009 болон 2019 оны хооронд гарсан арван жилийн дараах өөрчлөлтийг харьцуулан харуулжээ. Энэ хугацаанд 15-19 насны эмэгтэйчүүд болон 50-59 насны эмэгтэйчүүдийн

оролцоо өссөн бол харин 25-50 насны хамгийн өндөр оролцоотой эмэгтэйчүүдийнх буурсан байна.

Зураг.2 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, насны ангиллаар



Эх сурвалж: YCX

Хөдөлмөрийн зах зээлд хамгийн идэвхтэй оролцох насныхан буюу 25-50 насны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо арван жилийн хугацаанд буурсан байгаа нь маш сонирхолтой үйл явдал юм. Тиймээс энэхүү өөрчлөлтөд асран халамжлах ажил нөлөө үзүүлж буй эсэхийг тоон өгөгдөл болон үнэлгээний арга ашиглан уг ажлаараа тодорхойлох болно.

### 3. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлс болон тэр дундаа хүүхэд асран халамжлах ажлын талаар хийсэн гадаадын хэд хэдэн судалгааны ажлууд бий боловч манай улсад яг энэ чиглэлээр<sup>2</sup> хийгдсэн ажил одоогоор байхгүй. Харин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд бага насны хүүхэдтэй байх нь ямар нөлөө үзүүлж буй талаар судалсан ажлууд байдаг.

Altantsetseg ба Bayarmaa (2014) нь энэ ажилдаа 2002/2003, 2007/2008, 2010 оны МУ-ын АХС-ны тоон мэдээллийг ашиглан шугаман магадлалын загвар болон пробит загвараар үнэлгээ хийсэн бөгөөд бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох магадлал хүүхэдгүй эмэгтэйчүүдээс ойролцоогоор 7 хувиар бага байдаг гэсэн үр дүн гаргажээ. Мөн нийт хүүхдийн тоо (14-өөс доош насны) нэмэгдэхийн хэрээр хотод амьдардаг эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өндөр байх хандлагатай байдаг бол хөдөө орон нутгийн зургаагаас доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь хотод амьдардаг эмэгтэйчүүдийнх өндөр гэж үнэлэгдсэн байна. Хүүхдийн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд үзүүлэх энэхүү эсрэг нөлөө нь хөдөө орон нутаг болон хот суурин газрын эдийн засгийн үйл ажиллагааны ялгаатай байдлаас үүдэлтэй байж болно гэж дүгнэжээ.

Khishigt ба Hyung (2019) нарын ажил нь 2002/2003 оны ӨОЗНС, 2007/2008 оны ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан Монгол Улсын хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд үзүүлсэн нөлөөллийг хөтөлбөрт хамрагдсан болон хамрагдаагүй эмэгтэйчүүдийг харьцуулах замаар Difference-in-Difference арга мөн пробит загвараар судалжээ. Судалгааны үр дүнд хөтөлбөрт хамрагдсан хүүхэдтэй эмэгтэйчүүдийн харьцангуй ажиллах хүчний оролцоо 12.27 пунктээр, жилийн харьцангуй ажиллах цаг 155.32 цагаар буурсан гэж үнэлэгджээ. Мөн бага насны хүүхэдтэй байх нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох магадлалд сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Харин одоо эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт болон асран халамжлах ажлын талаар судалсан гадны ажлуудаас авч үзвэл:

---

<sup>2</sup> Care economy, care work

Bianchi (2012) судалгаандаа АНУ-ын 1965-2010 оны хоорондох нийт долоон удаагийн ЦАС-ны тоон мэдээллийг ашигласан ба АНУ-ын эмэгтэйчүүд, ялангуяа бага насны хүүхэдтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 1970-1990 оны хооронд хамгийн ихээр нэмэгдсэн бөгөөд хугацаа өнгөрөх тусам гэрийн ажил хийх, хүүхэд асрах хүйсийн хөдөлмөрийн хуваарилалт илүү тэгш болж, эрчүүдийн гэрийн ажилд зарцуулах хугацаа нэмэгдэж, харин эмэгтэйчүүдийн зарцуулах хугацаа эрс багасгасан гэсэн үр дүн гаргажээ. 1965 онд гэрлэсэн эмэгтэйчүүдийн долоо хоногт дунджаар 10.5 цагийг хүүхэд асрахад зарцуулдаг байсан бол 2010 онд 13.7 цаг болон нэмэгджээ. Харин гэрлэсэн эрэгтэйчүүдийнх энэ хугацаанд 2.6 цагаас 7.2 цаг болон бараг дахин гурав өсжээ. Гэрлэсэн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хүүхэд асрахад зарцуулж буй цаг хугацаа тавь орчим жилийн хугацаанд хүүхэд асрахад зарцуулж буй гэрлэсэн эрэгтэйчүүдийн цаг эмэгтэйчүүдийнхээс харьцангуйгаар нэмэгдсэн ч эмэгтэйчүүд илүү их хугацааг асран халамжлах ажилд зарцуулсаар л байна.

Fazio (2011) нар энэхүү ажлаараа хүүхэд, хөгшин хүн асрах нь гэрлэсэн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд ямар нөлөө үзүүлдгийг 1982, 1990, 2000 оны Хятадын хүн амын тооллогын судалгааны тоон мэдээллийг ашиглан пробит загвараар үнэлжээ. Судалгааны үр дүнд 2000 оны байдлаар 20-50 насны, гэрлэсэн, эмэгтэйн хувьд: Өрхөд 75 ба түүнээс дээш насны хүн байх нь ажиллах хүчний оролцоонд ач холбогдолтойгоор нөлөө үзүүлдэггүй ба өөрийн эцэг эх эсвэл хадам эцэг эхтэйгээ хамт амьдрах нь тухайн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог 6.6 пунктээр нэмэгдүүлдэг гэжээ. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй (65-аас доош насны) хамт амьдрах нь ажиллах хүчний оролцоонд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж, гэрлэсэн эмэгтэйчүүдийн оролцоог 8.1 пунктээр бууруулдаг байна. Мөн сургуулийн өмнөх насны хүүхдүүдтэй өрхийн ээжийн ажиллах хүчний оролцоо сургуулийн насны хүүхэдтэй гэрлэсэн, эмэгтэйчүүдтэй харьцуулахад 4.2 пунктээр бага байна гэж үнэлжээ.

Connolly (1992) энэхүү ажилдаа гэрлэсэн, хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд хүүхэд асрах зардлын нөлөөллийг судалсан. АНУ-ын 1984 оны Survey of Income and Program participation Panel (SIPP)-аас гэрлэсэн, 21-55 настай, 13-аас доош насны хүүхэдтэй, 2784 эмэгтэйн мэдээллийг авч ашиглан мөн пробит загвараар үнэлсэн байна. Судалгааны үр дүнгээс харвал 3-5 насны хүүхэдтэй эхчүүдийн хүүхэд асрах зардал

нь түүнээс дээш насны хүүхэдтэй эхчүүдээс илүү өндөр байдаг бол асран халамжлах үйлчилгээний төлбөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцооны хоорондын хамаарлын коэффициент  $-0.38$  гэж үнэлсэн ба хүүхэд асрах зардлыг бууруулах нь гэрлэсэн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд хүчтэй эерэг нөлөө үзүүлнэ гэж дүгнэжээ.

Bratti (2018) ажлаараа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд эцэг эх нь хүүхдийг нь асрах боломжтой байх нь ямар нөлөө үзүүлдгийг судалжээ. Шугаман магадлалын загвар ашиглан Италийн 1993-2006 оны "Survey of household income and wealth(SHIW)"-ээс 15-аас доош насны дор хаяж нэг хүүхэдтэй 20-49 насны эмэгтэйчүүдийн мэдээлэл дээр үнэлгээ хийсэн. Үр дүнгээс харвал судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд өөрийн эх нь тэтгэвэрт гарах боломжтой хүмүүсийн ажиллах хүчинд ажиллах магадлал нь ээж нь боломжгүй хүмүүстэй харьцуулахад 11% илүү байжээ.

Эдгээр судалгааны ажлуудыг ерөнхийд нь дүгнэхэд бага насны хүүхэдтэй байх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд сөрөг нөлөө үзүүлдэг буюу бууруулдаг хандлагатай байна.

#### 4. ЭМПИРИК АРГАЗҮЙ

Ажиллах хүчний оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх дийлэнх судалгааны ажлууд нь ихэвчлэн чанарын хариулт бүхий регрессийн загварыг(qualitative response model) ашиглаж үнэлгээгээ хийдэг. Чанарын хариулт бүхий регрессийн загварт шугаман магадлалын загвар, пробит загвар болон ложит загварууд багтдаг. Миний судалж буй чиглэлийн гадны болон дотоодын судалгаанууд нь ихэвчлэн пробит загварыг ашиглан хийгдсэн байдаг тул энэхүү ажилдаа пробит загвар ашиглан эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд асран халамжлах ажлын үзүүлж буй нөлөөг үнэлнэ.

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нас, насны квадрат, боловсрол, гэрлэлтийн байдал, байршил, хамт амьдардаг хүүхдийн тоо, өрхийн ам бүлийн тоо, 0-2 насны хүүхэд, хүүхэд асрах, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах болон өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асран халамжласан цаг ямар нөлөөлтийг доорх тэгшитгэлүүдийн дагуу үнэлнэ.

15-64 насны эмэгтэйчүүдийн пробит загварын үнэлгээний тэгшитгэл:

$$\text{Prob}(lfp_i = 1|X) = (\alpha_0 + \beta_0 X' + \beta_1 \text{childcare}_i + \beta_2 \text{eldercare}_i + \beta_3 \text{othermcare}_i)$$

Энд () нь стандарт нормаль тархалттай функц юм. Хамааран хувьсагч  $lfp_i$  нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох буюу хөдөлмөр эрхлэх магадлал. Харин  $X'$  нь тайлбарлагч хувьсагчдын вектор. Үүнд нас, насны квадрат, боловсрол, гэрлэлтийн байдал, байршил, хамт амьдардаг хүүхдийн тоо, өрхийн ам бүлийн тоо, 0-2 насны хүүхэдтэй эсэх зэрэг нь хамаарна.  $\text{childcare}_i$  нь хүүхэд асрахад зарцуулж буй хугацаа,  $\text{eldercare}_i$  нь өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрахад зарцуулж буй хугацаа,  $\text{othermcare}_i$  нь өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрахад зарцуулж буй хугацаа(цагаар) байна.

15-64 насны эмэгтэйчүүдийн шугаман регрессийн тэгшитгэл:

$$P_i = p(\text{weeklyworkhours}_i = 1) = \alpha_0 + \beta_0 X' + \beta_1 \text{childcare}_i + \beta_2 \text{eldercare}_i + \beta_3 \text{othermcare}_i + u_i$$

Энд () нь стандарт нормаль тархалттай функц юм. Хамааран хувьсагч  $\text{weeklyworkhours}_i$  нь хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн долоо хоногт хөлстэй хөдөлмөрт зарцуулсан цаг.

Амьдардаг газрын ялгаатай байдлаас үүдэн асран халамжлах ажлын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө нь өөр өөр байж болох тул тоон өгөгдлөө гэр хороолол болон орон сууцанд амьдардаг эсэхээр салгаж мөн үнэлнэ.

## 5. ТООН ӨГӨГДӨЛ


Энэхүү ажилдаа ҮСХ-оос гаргадаг ЦАС-ны 2019 оны тоон мэдээллийг ашигласан. Цаг ашиглалтын судалгааг манай улс 2007 оноос хойш авч эхэлсэн бөгөөд 2011, 2015, 2019 он гэсэн дөрвөн удаагийн тоон мэдээллийг цуглуулаад байгаа ба өрхийн асуулга, тав хүртэлх насны хүүхдийн асуулга, өдрийн тэмдэглэл гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг. 2019 оны судалгаанд 3,972 өрхийн 13,499 хүн оролцсон бөгөөд үүнээс 12 ба түүнээс дээш насны 6,312 хүн өдрийн тэмдэглэл хөтөлсөн байна. Тоон мэдээлэл маань тус тусдаа өгөгдлүүд байсан учир судалгаанд ашиглахуйц болгохын тулд анхан шатны боловсруулалт хийсэн. Судалгааны ажлын гол тоон мэдээлэл болох “Өдрийн тэмдэглэл”-ийн мэдээлэл нь тухайн хүн тус бүрээр хоногийн 24 цагийн турш хийсэн үйл ажиллагааг арав арван минутын интервалаар салган тэмдэглэсэн төдийгүй үргэлжилсэн хэлбэртэй байсан тул үүнээс гэр бүлийн гишүүнийг асран халамжилсан хугацааг кодоор нь ялгаж авсан. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын үзүүлэх нөлөөг судлах гэж байгаа тул ҮСХ-ны ажиллах хүчний оролцоог тооцдог тодорхойлолтын дагуу нийт тоон өгөгдлөөс 15-64 насны 4,290 эмэгтэйчүүдийн мэдээллийг ялган авч судалгаандаа ашиглалаа.

2019 оны ЦАС-ны мэдээлэл цуглуулах ажлыг улирлаар зохион байгуулсан бөгөөд 2019 оны гурав, зургаа, ес, арван хоёрдугаар сарын гурав дахь долоо хоногт зохион байгуулан явуулсан гэж тайланд дурджээ. Мөн судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг сонгогдсон аймгийн Статистикийн хэлтсийн дарга нар ахалж, өрхөд суурилсан судалгааны ярилцлага авагч нар мэдээлэл цуглуулсан ба ЦАС-ны нэг зорилго нь 7 хоногийн өдрүүдэд хүн амын хийж буй ажлын ялгаатай байдлыг харах учраас судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг улирал бүр нэг бүтэн долоо хоногийг хамруулж өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн байна. Цаасаар өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн тохиолдолд ярилцлага авагч хөдөөгийн өрхөд 2 удаа, хот, суурин газарт 3 удаа өрхдөө очиж өдрийн тэмдэглэлийн хөтлөлтийг шалгаж заавар өгч байсан бөгөөд гар утасны аппликейшн ашиглаж өдрийн тэмдэглэл хөтөлсөн тохиолдолд өрхөд ганц удаа очсон ба цахим платформ ашиглаж судалгаанд хамрагдагчид заавар, мэдээллийг хүргүүлжээ. Үүнээс үзвэл 2019 оны цаг ашиглалтын судалгааны өрхүүдийн түүврийг санамсаргүй байдлаар сонгож, тоон мэдээллийг нарийн зохион байгуулалттайгаар цуглуулсан гэж үзэж байна.

ЦАС-нд ашигладаг гол арга буюу өдрийн тэмдэглэл хөтлүүлэн судалгааны тоон өгөгдлийг цуглуулах нь түүнд хариулт өгч байгаа хүмүүсийн өдөр, цаг тутмын үйл ажиллагааг өөрсдөөр нь тэмдэглүүлэн авч, тоон мэдээллийг цуглуулах судалгааны арга юм. (Mariño et al. 1999; Bowling 2002). Мөн өдрийн тэмдэглэл нь үйл явдлуудад цаг хугацааны явцад дүн шинжилгээ хийх боломжийг олгодог (Mariño et al. 1999) ба ажиглалтын олон аргуудын нэгэн адил үйл явдлыг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд илүү өргөн хүрээнд байрлуулахад тусалдаг. (Mariño et al. 1999). Энэ аргыг хоол тэжээлийн хэмжээ, зардлыг тооцох (Rush et al. 1988a), жирэмсэн эмэгтэйчүүдийн зардлыг тооцох, (Rush et al. 1988b), эрүүл мэндийн үйлчилгээ, зардлыг хэмжих (March et al. 2004), сахрын өвчний явцыг судлах (Cameron et al. 2004), архины хэрэглээг хэмжих (Flegal 1990; O'Hare 1991; Leigh 1993) зэрэг судалгаануудад ашигласан байна. Эрүүл мэндийн өдрийн тэмдэглэлийн тоон өгөгдөл дээр ажилласан судлаач Verbrugge (1980: 90) нь хэрвээ судлаачид тэмдэглэл хөтөлж байгаа хүмүүстэй эргэж уулзаж, зарим хариулт оруулах тал дээрх асуултад хариулж чадаж байвал өдрийн тэмдэглэл бол зарим гажилтуудыг арилгаж, асуулга шиг чанартай мэдээлэл, тоон өгөгдлийг олгох боломжтой гэж дүгнэсэн байна. ЦАС хийсэн орнуудаас Хятад, Тайланд зэрэг улсууд зөвхөн оролцогчдын өөрсдийн тэмдэглэсэн өдрийн тэмдэглэлийг ашигладаг бол Монгол болон Пакистан улс бичиг үсэгт тайлагдсан хүн амдаа ийм өдрийн тэмдэглэл ашиглаж, бичиг үсэг тайлагдаагүй хүмүүстэй нүүр тулсан ярилцлага хийж мэдээллийг нь авдаг. Монголын 2019 оны ЦАС бол бичиг үсэг сайн тайлагдсан болон тааруу бичиж, уншдаг хүмүүсийг бүгдийг хамруулсан түүвэр судалгаа болж чадсан гэж үзэж байна. Бангладеш, Энэтхэг, Монгол болон Пакистан зэрэг улсуудын судлаачид цаг ашиглалтын судалгаанд оролцогчидтой очиж уулзаж, нүүр тулсан ярилцлага хийхэд хүн тус бүрт дор хаяж 30 минут зарцуулсан байна. Иймээс энэхүү судалгааны ажилдаа ашиглаж байгаа тоон мэдээлэл нь түүвэр сонголтын гажилтгүй тоон өгөгдөл юм.

Одоо судалгааны тоон өгөгдлийн зарим статистик шинж чанарыг танилцуулъя. Судалгаанд хамрагдсан 15-64 настай эмэгтэйчүүдийг насны ангиллаар нь харвал 30-34 насныхан хамгийн их буюу ойролцоогоор 13 хувь орчим, 60-64 насныхан хамгийн бага буюу зургаан хувийг эзэлж байна. Судалгааны ажлын түүвэрт эзлэх эмэгтэйчүүдийн хувийг насны ангиллаар харахад хоорондоо хол зөрүүгүй байгаа бөгөөд аль ч насны эмэгтэйг түүвэрт ерөнхийдөө жигд хамруулжээ.

Зураг.3 Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн насны ангилал



Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал нийт 4290 эмэгтэйн 59 хувь нь ямар нэг байдлаар ажиллах хүчинд оролцдог бол үлдсэн 41 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн амд харьяалагддаг байна. Ажиллах хүчинд оролцдоггүй эмэгтэйчүүдийн 16 хувь нь огт гэрлээгүй, 20 хувь нь батлуулсан болон батлуулаагүй гэрлэсэн бол таван хувь нь салсан/үүнд цуцлуулсан, тусгаарласан мөн бэлэвсэн/ байна. Харин хөдөлмөр эрхэлдэг арван эмэгтэй тутмын найм нь гэр бүлтэй байгаа бол үлдсэн хоёрын нэг нь салсан, нэг нь огт гэрлээгүй хүн байна.


Хүснэгт.1 Ажиллах хүчинд оролцдог эсэх, гэрлэлтийн байдлаар

| АХО  | Огт гэрлээгүй |      | Батлуулсан гэр бүлтэй |      | Батлуулаагүй гэр бүлтэй |      | Салсан |      | Нийт  |
|------|---------------|------|-----------------------|------|-------------------------|------|--------|------|-------|
|      | Тоо           | Хувь | Тоо                   | Хувь | Тоо                     | Хувь | Тоо    | Хувь |       |
| Үгүй | 678           | 16%  | 709                   | 17%  | 145                     | 3%   | 220    | 5%   | 1752  |
| Тийм | 322           | 8%   | 1755                  | 41%  | 199                     | 5%   | 262    | 6%   | 2538  |
| Нийт | 1,000         | 23%  | 2,464                 | 57%  | 344                     | 8%   | 482    | 11%  | 4,290 |

Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан 15-64 насны нийт эмэгтэйчүүдийн 33 хувь нь хотод амьдардаг бол 20 хувь нь аймгийн төвд, 19 хувь нь сумын төвд 28 хувь нь хөдөө буюу багт амьдардаг. Түүврийн 67 хувь нь хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүд байсан.

Зураг.4 Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд байршлаар



Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Доорх хүснэгтээс харвал нийт эмэгтэйчүүдийн тал хувь нь ямар нэг байдлаар 16 хүртэлх насны нэг ч хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй эсвэл хүүхэдгүй хүмүүс байна. Харин 19.2 хувь буюу 823 эмэгтэй нэг хүүхэдтэйгээ, 17.5 хувь буюу 751 эмэгтэй 16 хүртэлх насны хоёр хүүхэдтэйгээ хамт амьдардаг. Судалгааны түүвэрт хамгийн ихдээ зургаан хүүхэдтэйгээ хамт амьдардаг эмэгтэй байгаа бөгөөд энэ нь ердөө 0.04 хувийг эзэлж байсан. Гурав, дөрөв болон таван хүүхэдтэйгээ амьдардаг ээжүүд харгалзан 8.5 хувь, 4.7 хувь, 0.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт.2 16 хүртэлх насны хамт амьдардаг хүүхдийн тоо, байршлаар


|                          | Хөдөө |        | Хот   |        | Нийт  |
|--------------------------|-------|--------|-------|--------|-------|
|                          | Тоо   | Хувь   | Тоо   | Хувь   |       |
| <b>Хамт амьдардаггүй</b> | 1,459 | 34.01% | 699   | 16.29% | 2,158 |
| <b>1</b>                 | 551   | 12.84% | 272   | 6.34%  | 823   |
| <b>2</b>                 | 479   | 11.17% | 272   | 6.34%  | 751   |
| <b>3</b>                 | 248   | 5.78%  | 119   | 2.77%  | 367   |
| <b>4</b>                 | 108   | 2.52%  | 54    | 1.26%  | 162   |
| <b>5</b>                 | 17    | 0.40%  | 10    | 0.23%  | 27    |
| <b>6</b>                 | 1     | 0.02%  | 1     | 0.02%  | 2     |
| <b>Нийт</b>              | 2,863 | 66.74% | 1,427 | 33.26% | 4,290 |

Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Эмэгтэйчүүдийн боловсролын байдлыг авч үзвэл хоёр хувь нь боловсрол эзэмшээгүй, зургаан хувь нь бага боловсролтой бол 18 хувь нь суурь боловсрол эзэмшжээ. Хамгийн их хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн ба энэ нь судалгаанд хамрагдсан

эмэгтэйчүүдийн 32 хувь нь байна. Дээд боловсрол буюу бакалавр болон түүнээс зэргийн боловсролыг 25 хувь буюу 1068 эмэгтэй эзэмшсэн. Боловсролын байдлыг харвал хөдөө амьдардаг эмэгтэйчүүдийн бүрэн дунд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүд хамгийн их нь байгаа бол хотын эмэгтэйчүүдийн хувьд дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна.


Зураг.5 Боловсролын байдал, байршилаар



Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан 15-64 насны эмэгтэйчүүд дунджаар дөрвөн ам бүлтэй байна. Хамгийн ихдээ 11 гишүүнтэй өрх байгаа бол ганцаараа амьдардаг 141 эмэгтэй байсан.


Зураг.6 Өрхийн гишүүдийн тоо, давтамжаар



Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Судалгааны ажлын голлон анхаарч судалж байгаа зүйл буюу асран халамжлах ажилд зарцуулж байгаа цаг болон хөлстэй хөдөлмөрт зарцуулж байгаа цагийн хооронд сөрөг хамаарал харагдаж байна. Энэ нь эмэгтэйчүүдийн хэн нэгнийг асран халамжлах ажил нь хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн утгатай.

*Зураг.7 Долоо хоногийн хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг болон ажлын 1 өдөрт хүүхэд асрахад зарцуулж буй хугацааны хамаарал*



*Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол*

Судалгаандаа ашиглах тоон өгөгдөлдөө боловсруулсны дараа хетероскедаст болон мультиколинеар байдлыг шалгах тестүүдийг хийсэн бөгөөд үр дүнг Хавсралт.2 болон 3-аас харна уу. Тестийн үр дүнгээс харахад үнэлгээндээ ашиглаж байгаа хувьсагчид хоорондоо өндөр хамаарал байхгүй бөгөөд хамааран хувьсагчийн маань вариаци нь тогтмол гэсэн үндэслэлтэй байна.

Үнэлгээндээ ашигласан хувьсагчдын дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт.4-оос харна уу. Тоон өгөгдлийн хураангуй тайлбарлагч шинж чанарын мэдээллийг Хавсралт.5, 6 болон 7-оос харна уу.

## 6. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлс болон асран халамжлах ажлын үзүүлэх нөлөөг пробит загвар ашиглан үнэллээ. Пробит загвараар үнэлсэн үр дүнгээ доорх Хүснэгт.3-т харууллаа. 15-64 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлалд нас, бакалаврын боловсрол, гэрлэсэн болон салсан, нэг болон хоёр хүүхэдтэйгээ хамт амьдардаг байх нь эерэг нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт.3 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн пробит загварын үр дүн*

| Пробитын үр дүн                                                             | Нийт                 | Гэр хороолол         | Орон сууц            |
|-----------------------------------------------------------------------------|----------------------|----------------------|----------------------|
| Нас                                                                         | 0.272***<br>(0.013)  | 0.265***<br>(0.014)  | 0.321***<br>(0.035)  |
| Насны квадрат                                                               | -0.003***<br>(0.000) | -0.003***<br>(0.000) | -0.004***<br>(0.000) |
| Бакалавр                                                                    | 0.377***<br>(0.055)  | 0.455***<br>(0.069)  | 0.396***<br>(0.116)  |
| Гэрлэсэн                                                                    | 0.468***<br>(0.080)  | 0.516***<br>(0.086)  | 0.163<br>(0.220)     |
| Салсан                                                                      | 0.295***<br>(0.104)  | 0.322**<br>(0.114)   | 0.066<br>(0.259)     |
| Хот                                                                         | -0.319***<br>(0.048) | -0.288***<br>(0.056) | -0.187*<br>(0.114)   |
| 1 хүүхэдтэй хамт амьдардаг                                                  | 0.235***<br>(0.069)  | 0.213**<br>(0.075)   | 0.343*<br>(0.183)    |
| 2 хүүхэдтэй хамт амьдардаг                                                  | 0.208***<br>(0.081)  | 0.240**<br>(0.089)   | 0.183<br>(0.205)     |
| 3-6 хүүхэдтэй хамт амьдардаг                                                | 0.103<br>(0.095)     | 0.096<br>(0.104)     | 0.275<br>(0.253)     |
| Өрхийн ам бүлийн тоо                                                        | -0.060***<br>(0.016) | -0.059***<br>(0.018) | -0.090**<br>(0.045)  |
| Хүүхэд асрахад зарцуулж буй хугацаа                                         | -0.220***<br>(0.016) | -0.217***<br>(0.019) | -0.234***<br>(0.037) |
| Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрахад зарцуулж буй хугацаа | -0.248**<br>(0.105)  | -0.284**<br>(0.130)  | -0.157<br>(0.185)    |
| Өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрахад зарцуулж буй хугацаа           | -0.094<br>(0.083)    | -0.107<br>(0.087)    | -0.146<br>(0.304)    |
| 0-2 насны хүүхэд                                                            | -0.233***<br>(0.061) | -0.224***<br>(0.069) | -0.306**<br>(0.141)  |
| Ажиглалтын утга                                                             | 4290                 | 3499                 | 791                  |
| Pseudo-R2                                                                   | 0.265                | 0.261                | 0.295                |

Тэмдэглэгээ: ()стандарт алдаа. \*\*\*, \*\*, \* тус бүр 1%, 5%, 10%-ийн түвшинд ач холбогдолтой.

Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Харин насны квадрат, хотод амьдардаг байх, өрхийн ам бүлийн тоо, хүүхэд асрахад зарцуулж буй цаг, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрахад зарцуулж буй цаг, 0-2 насны хүүхэдтэй байх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох магадлалд сөрөг нөлөө үзүүлдэг гэж үнэлэгджээ.

Пробит загварын үр дүнг ихэвчлэн ахиу нөлөөллөөр тайлбарладаг ба ахиу нөлөөллийн үр дүнг Хүснэгт.4-т харуулав. Эмэгтэйчүүдийн нас нэгээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэлтэд оролцох магадлал нь 7.6 хувиар өсөж байна. Бакалаврын боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд ажиллах хүчинд оролцох магадлал нь түүнээс бага боловсролтой эмэгтэйчүүдтэй харьцуулахад (пробитын ахиу нөлөө) 10.5 хувиар өндөр гэж үнэлэгджээ. Харин гэрлэсэн болон гэрлэлтээ цуцлуулсан(тусгаарласан болон бэлэвсэн) эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлал нь огт гэрлээгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад харгалзан 13.1 хувь болон 8.2 хувиар илүү байна. Хотод амьдардаг судалгаанд оролцсон 15-64 насны эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээлд оролцох магадлал нь хөдөө амьдардаг эмэгтэйчүүдээс 8.9 хувиар бага байна. 16-аас доош насны нэг эсвэл хоёр хүүхэдтэйгээ хамт амьдардаг байх нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны магадлалд эерэг нөлөө үзүүлдэг гэж үнэлэгджээ. Эмэгтэйчүүдийн хүүхэд асрах цаг нэгээр нэмэгдэхэд ажиллах хүчинд оролцох магадлал нь 6.2 хувиар, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах цаг нэгээр нэмэгдэхэд 7.0 хувиар буурдаг ба энэхүү үнэлгээ нь харгалзан 1% болон 5 %-ийн түвшинд ач холбогдолтой байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд 0-2 насны хүүхэд бол хөдөлмөр эрхлэх магадлал нь үүнээс дээш насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 6.5 хувиар бага байгаа нь Altantsetseg ба Bayarmaa (2014), Khishigt ба Nyung (2019) болон Fazio (2011) нарын судалгааны үр дүнтэй ижил байна.

*Хүснэгт.4 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн пробитын ахиу нөлөө*

| Пробитийн ахиу нөлөө | Нийт                 | Гэр хороолол         | Орон сууц            |
|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| <b>Нас</b>           | 0.076***<br>(0.003)  | 0.074***<br>(0.003)  | 0.087***<br>(0.008)  |
| <b>Насны квадрат</b> | -0.001***<br>(0.000) | -0.001***<br>(0.000) | -0.001***<br>(0.000) |
| <b>Бакалавр</b>      | 0.105***<br>(0.015)  | 0.127***<br>(0.019)  | 0.107***<br>(0.031)  |
| <b>Гэрлэсэн</b>      | 0.131***<br>(0.022)  | 0.145***<br>(0.024)  | 0.044<br>(0.059)     |
| <b>Салсан</b>        | 0.082***<br>(0.029)  | 0.090**<br>(0.032)   | 0.018*<br>(0.070)    |

|                                                                                    |                      |                      |                      |
|------------------------------------------------------------------------------------|----------------------|----------------------|----------------------|
| <b>Хот</b>                                                                         | -0.089***<br>(0.013) | -0.081***<br>(0.016) | -0.051*<br>(0.031)   |
| <b>1 хүүхэдтэй хамт амьдардаг</b>                                                  | 0.066***<br>(0.019)  | 0.060**<br>(0.021)   | 0.093*<br>(0.049)    |
| <b>2 хүүхэдтэй хамт амьдардаг</b>                                                  | 0.058***<br>(0.022)  | 0.067**<br>(0.025)   | 0.049<br>(0.055)     |
| <b>3-6 хүүхэдтэй хамт амьдардаг</b>                                                | 0.029<br>(0.027)     | 0.027<br>(0.029)     | 0.074<br>(0.068)     |
| <b>Өрхийн ам бүлийн тоо</b>                                                        | -0.017***<br>(0.005) | -0.017***<br>(0.005) | -0.024**<br>(0.012)  |
| <b>Хүүхэд асрахад зарцуулж буй хугацаа</b>                                         | -0.062***<br>(0.004) | -0.061***<br>(0.005) | -0.063***<br>(0.009) |
| <b>Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрахад зарцуулж буй хугацаа</b> | -0.070**<br>(0.029)  | -0.080**<br>(0.036)  | -0.042<br>(0.050)    |
| <b>Өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрахад зарцуулж буй хугацаа</b>           | -0.026<br>(0.023)    | -0.030<br>(0.024)    | -0.039<br>(0.082)    |
| <b>0-2 насны хүүхэд</b>                                                            | -0.065***<br>(0.017) | -0.063***<br>(0.019) | -0.083**<br>(0.038)  |
| <b>Ажиглалтын утга</b>                                                             | 4290                 | 3499                 | 791                  |
| <b>Pseudo-R<sup>2</sup></b>                                                        | 0.265                | 0.261                | 0.299                |

Тэмдэглэгээ: ()стандарт алдаа. \*\*\*, \*\*, \* тус бүр 1%, 5%, 10%-ийн түвшинд ач холбогдолтой.

Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын үзүүлэх нөлөө нь амьдардаг газрын ялгаатай байдлаас үүдэн өөр өөр байх боломжтой гэж таамагласан тул гэр хороолол болон орон сууцанд амьдардаг эсэхээр нь салган үнэлсэн үр дүнг Хүснэгт.4-ийн гурав болон дөрөвдүгээр баганаас харж болно. Гэр хороололд амьдардаг бакалаврын боловсролтой эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох магадлал нь орон сууцанд амьдардаг бакалаврын боловсролтой эмэгтэйчүүдээс 2 хувиар өндөр байна. Мөн гэр хороололд амьдардаг гэрлэсэн болон салсан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлал нь орон сууцанд амьдардаг ижил шинж чанартай эмэгтэйчүүдээс илүү өндөр гэж үнэлэгджээ. Харин хотод гэр хороололд амьдардаг байх нь эмэгтэй хүмүүсийн ажиллах хүчинд оролцох магадлалыг 8.1 хувиар бууруулдаг бол хотод орон сууцанд амьдардаг байх нь 5.1 хувиар бууруулдаг. Орон сууцанд амьдардаг эмэгтэй 16-аас доош насны нэг хүүхэдтэйгээ амьдардаг байх нь гэр хороололд амьдардаг ижил шинж чанартай эмэгтэйтэй харьцуулахад хөдөлмөрийн зах зээлд оролцох магадлал нь 3.3 хувиар илүү байна. Гэр хороолол болон орон сууцанд амьдардаг эмэгтэйчүүдийн хүүхэд асрахад зарцуулж буй хугацаа нь ажиллах хүчинд оролцох магадлалыг маш ойролцоо хувиар бууруулж байна. Харин өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн

гишүүнийг асрахад зарцуулж буй хугацаа нь гэр хороололд амьдардаг эмэгтэйн хөдөлмөр эрхлэх магадлалыг орон сууцанд амьдардаг эмэгтэйнхээс илүү ихээр бууруулдаг гэсэн үр дүнг өгчээ.

Одоо харин судалгаанд оролцсон хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн долоо хоногийн цалин хөлстэй ажилласан цагт нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг үнэлсэн шугаман регрессийн загварын үр дүнгээс харвал нас, насны квадрат, бакалаврын боловсрол, хотод амьдардаг байх, хүүхэд асран халамжилсан хугацаа болон 0-2 насны хүүхэдтэй байх зэрэг хувьсагчууд нь ач холбогдолтой үнэлэгджээ/Хавсралт.8 харна уу/. 15-64 насны эмэгтэйчүүдийн цалин хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй хугацааг хүүхэд асран халамжлах ажилд зарцуулж буй цаг болон 0-2 насны хүүхэдтэй байх нь бууруулдаг байна. Эмэгтэйчүүдийн хүүхэд асрах цаг нэгээр нэмэгдэхэд хөлстэй хөдөлмөрт зарцуулах хугацаа нь 2.3 цагаар буурдаг байна. Харин 0-2 насны хүүхэдтэй бол эмэгтэйчүүдийн долоо хоногийн ажлын цаг үүнээс дээш насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2.4 цагаар буурдаг гэсэн үр дүн нь Khishigt ба Hyung (2019) нарын судалгааны ажлын үр дүнтэй нийцтэй байна.

## 7. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаараа 2019 оны “Цаг ашиглалтын судалгаа”-наас 15-64 насны 4290 эмэгтэйн тоон мэдээллийг ашиглан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс болон тэр дундаа асран халамжлах ажлын үзүүлэх нөлөөг судаллаа. Өмнө нь ашиглаж байгаагүй тоон мэдээлэл болон эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөө үзүүлж болох шинэ хүчин зүйлийг оруулж үнэлсэн нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал нь болсон гэж үзэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэйчүүдийн нас, бакалаврын боловсрол, гэрлэсэн болон салсан байдал, нэг болон хоёр хүүхэдтэй байх нь ажиллах хүчний оролцоонд ач холбогдолтойгоор эерэг нөлөө үзүүлдэг бол насны квадрат, хотод амьдардаг байх, өрхийн ам бүлийн тоо, хүүхэд асрахад зарцуулж буй цаг, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрахад зарцуулж буй цаг, 0-2 насны хүүхэдтэйгээ хамт амьдардаг байх нь сөрөг нөлөө үзүүлдэг. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд 0-2 насны хүүхэд бол хөдөлмөр эрхлэх магадлал нь үүнээс дээш насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 6.5 хувиар бага байгаа нь Altantsetseg ба Bayarmaa (2014), Khishigt ба Hyung (2019) болон Fazio (2011) нарын судалгааны үр дүнтэй ижил байна. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрахад зарцуулж буй цаг нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд сөргөөр нөлөөлж байгаа нь Fazio (2011) ажилтай ижил үр дүн өгсөн байна. Харин тухайн эмэгтэй гурваас зургаан хүүхэдтэй байх болон өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрахад зарцуулж буй цаг зэрэг нь ач холбогдолгүй үнэлэгдсэн байна.

15-64 насны эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох магадлалд гэр бүлийн гишүүдийг асран халамжлах ажил нь сөрөг нөлөө үзүүлдэг буюу хөдөлмөр эрхлэлтийг нь бууруулдаг байна.

Энэхүү ажилд ашигласан тоон мэдээлэл буюу ЦАС нь 2011 болон 2015 онд хийгдэж байсан тул эдгээр онуудын өгөгдлийг ашиглан асран халамжлах ажлын үзүүлж буй нөлөөг хугацаагаар нь харьцуулалт хийж өргөтгөх боломжтой.

## НӨМЗҮЙ

Altantsetseg, B. Bayarmaa, D. 2014, “Labor force participation and earning in Mongolia”, ERI Discussion, Paper, Series No. 3, Ulaanbaatar.

Anderson, P. M., & Levine, P. B. (1999). Child care and mothers' employment decisions.

Bianchi, S. M., Sayer, L. C., Milkie, M. A., & Robinson, J. P. (2012). Housework: Who did, does or will do it, and how much does it matter?. *Social forces*, 91(1), 55-63.

Bick, A. (2016). The quantitative role of child care for female labor force participation and fertility. *Journal of the European Economic Association*, 14(3), 639-668.

Bratti, M., Frattini, T., & Scervini, F. (2018). Grandparental availability for child care and maternal labor force participation: pension reform evidence from Italy. *Journal of Population Economics*, 31(4), 1239-1277.

Connelly, R. (1992). The effect of child care costs on married women's labor force participation. *The review of Economics and Statistics*, 83-90.

Dandarchuluun, K., & Choi, H. J. (2019). The effect of universal child benefit on female labor supply: Case of Mongolia. *Asian Journal of Social Sciences & Humanities Vol*, 8(2).

International labor organization (2018). Time-use surveys and statistics in Asia and the Pacific: A review of challenges and future directions

Maurer-Fazio, M., Connelly, R., Chen, L., & Tang, L. (2011). Childcare, eldercare, and labor force participation of married women in urban China, 1982–2000. *Journal of human resources*, 46(2), 261-294.

Nicodemo, C., & Waldmann, R. (2009). Child-care and participation in the labor market for married women in Mediterranean countries.

Wiseman, V., Conteh, L., & Matovu, F. (2005). Using diaries to collect data in resource-poor settings: questions on design and implementation. *Health Policy and Planning*, 20(6), 394-404.

Үндэсний статистикийн газар 2019, Цаг ашиглалтын судалгааны тайлан, Улаанбаатар хот, Монгол улс

## ХАВСРАЛТ

*Хавсралт.1 Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал*

### **Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах**

#### ***Хүүхэд асрах***

**Код**    **Тайлбар**

- |            |                                                                                  |
|------------|----------------------------------------------------------------------------------|
| <b>411</b> | Хүүхэд асрах (хооллох, усанд оруулах, унтуулах, живх солих г.м)                  |
| <b>412</b> | Хүүхэд өвдсөн үед асрах, эм өгөх, эмчилгээ хийх                                  |
| <b>413</b> | Хүүхдэд даалгавар хийхэд туслах, сургах                                          |
| <b>414</b> | Хүүхдэд үлгэр, ном уншиж өгөх, ярилцах                                           |
| <b>415</b> | Хүүхэдтэй тоглох                                                                 |
| <b>416</b> | Хүүхдээ харах (идэвхгүй хэлбэр буюу унтаж байхад нь, тоглож байхад нь харах г.м) |
| <b>417</b> | Хүүхдийнхээ сургууль, цэцэрлэг орох, багштай уулзах                              |
| <b>419</b> | Хүүхэд асрахтай холбогдох бусад үйл ажиллагаа                                    |
| <b>442</b> | Хүүхэдтэйгээ хамт явах, зорчих                                                   |

#### ***Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүн асрах***

- |            |                                                                                                                      |
|------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>421</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүний өдөр тутмын үйл ажиллагаанд туслах                    |
| <b>422</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх (эмийг нь өгөх)          |
| <b>423</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд бичиг баримт бүрдүүлэх, банкны үйлчилгээ авахад туслах |
| <b>424</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, ярилцах                |
| <b>425</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнийг харах (идэвхгүй хэлбэрээр)                           |
| <b>426</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүн асрах үйлчилгээ үзүүлдэг хүнтэй уулзах                  |
| <b>429</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүн асрахтай холбогдох бусад үйл ажиллагаа                  |
| <b>443</b> | Өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнтэй хамт явах, зорчих                                    |

#### ***Өрхийн насанд хүрсэн бусад гишүүдэд анхаарал тавих***

- |            |                                                                             |
|------------|-----------------------------------------------------------------------------|
| <b>431</b> | Түр зуурын өвчний үед өрхийн насанд хүрсэн бусад гишүүдийг хооллох, асрах   |
| <b>432</b> | Өрхийн насанд хүрсэн бусад гишүүдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, ярилцах |

- 439 Өрхийн насанд хүрсэн бусад гишүүдэд анхаарал тавихтай холбогдох бусад үйл ажиллагаа
- 441 Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахтай холбогдон явах, зорчих
- 444 Өрхийн насанд хүрсэн бусад гишүүнтэй хамт явах, зорчих
- 490 Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахтай холбогдох бусад үйл ажиллагаа

*Хавсралт.2 Хетероскедаст байдал шалгах тестийн үр дүн*

|                                                                  |          |
|------------------------------------------------------------------|----------|
| Breusch-Pagan / Cook-Weisberg test for heteroskedasticity        |          |
| Ho: Constant variance<br>Variables: fitted values of weeklyhours |          |
| chi2(1)                                                          | = 1.25   |
| Prob > chi2                                                      | = 0.2636 |

*Хавсралт.3 Мультиколлинеар байдал шалгах тестийн үр дүн*

| Variable          | VIF   | 1/VIF    |
|-------------------|-------|----------|
| age2              | 60.90 | 0.016421 |
| age               | 59.82 | 0.016717 |
| married           | 2.55  | 0.392123 |
| child36           | 2.26  | 0.443267 |
| seperated         | 2.22  | 0.450016 |
| child2            | 1.98  | 0.504678 |
| numberoffhmembers | 1.64  | 0.609456 |
| child1            | 1.59  | 0.628505 |
| child02           | 1.31  | 0.763429 |
| childh            | 1.23  | 0.813806 |
| bachelor          | 1.14  | 0.877617 |
| city              | 1.10  | 0.905635 |
| othermh           | 1.04  | 0.961307 |
| elderh            | 1.01  | 0.987178 |
| Mean VIF          | 9.99  |          |

*Хавсралт.4 Хувьсагчдын тайлбар*

| <b>Хувьсагчид</b>                                                  | <b>Тайлбар</b>                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|--------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хөдөлмөр эрхлэлт</b>                                            | Сүүлийн долоо хоногт дор хаяж 1 цаг ямар нэг цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн, сүүлийн долоо хоногт орлого олох зорилгоор дор хаяж 1 цаг ямар нэгэн бизнес, өрхийн болон ХАА үйл ажиллагаа эрхэлсэн болон сүүлийн долоо хоногт хөдөлмөр эрхлээгүй боловч ер нь тогтмол ажилтай бол 1 гэсэн утга авдаг дамми, бусад тохиолдолд 0 |
| <b>Нас</b>                                                         | 15-64 насны эмэгтэйчүүдийн насны тоо                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>Өрхийн гишүүдийн тоо</b>                                        | Тухайн өрхийн гэр бүлийн гишүүдийн тоо                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>Байршил</b>                                                     | Хотод амьдардаг бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Гэрлэлтийн байдал - гэрлэсэн</b>                                | Батлуулсан бол батлуулаагүй гэрлэсэн бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Гэрлэлтийн байдал - цуцалсан</b>                                | Гэрлэлтээ тусгаарласан, цуцалсан болон бэлэвсэн бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                   |
| <b>0-2 насны хүүхэд</b>                                            | Тухайн өрхөд 0, 1, 2 насны хүүхэд байдаг бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                          |
| <b>1 хүүхэдтэй</b>                                                 | Тухайн өрхөд 16-аас доош насны 1 хүүхэд байдаг бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                    |
| <b>2 хүүхэдтэй</b>                                                 | Тухайн өрхөд 16-аас доош насны 2 хүүхэд байдаг бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                    |
| <b>3-6 хүүхэдтэй</b>                                               | Тухайн өрхөд 16-аас доош насны 3-6 хүүхэд байдаг бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                  |
| <b>Боловсрол - бакалавр болон магистр</b>                          | Их дээд сургууль төгссөн болон магистрт сурсан бол 1 гэсэн утга авдаг дамми                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Асрах ажил - хүүхэд</b>                                         | Ажлын 1 өдөрт хүүхэд асрахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа /цагаар/                                                                                                                                                                                                                                            |
| <b>Асрах ажил - өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүн</b> | Ажлын 1 өдөрт хөгшин настай болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийг асрахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа /цагаар/                                                                                                                                                                                                |

|                                                       |                                                                                                                       |
|-------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Асрах ажил - өрхийн насанд хүрсэн бусад гишүүн</b> | Ажлын 1 өдөрт гэр бүлийн бусад насанд хүрсэн гишүүнийг асрахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа /цагаар/ |
| <b>Ажилласан цаг</b>                                  | Сүүлийн долоо хоногт хөлстэй хөдөлмөрт зарцуулсан нийт цаг                                                            |

*Хавсралт.5 Тоон өгөгдлийн шинж чанар*

| <b>Variable</b>          | <b>Obs</b> | <b>Mean</b> | <b>Std. Dev.</b> | <b>Min</b> | <b>Max</b> |
|--------------------------|------------|-------------|------------------|------------|------------|
| <b>lfp</b>               | 4,290      | 0.591608    | 0.491594         | 0          | 1          |
| <b>age</b>               | 4,290      | 38.23217    | 13.43562         | 15         | 64         |
| <b>age2</b>              | 4,290      | 1642.172    | 1055.64          | 225        | 4096       |
| <b>bachelor</b>          | 4,290      | 0.248951    | 0.432456         | 0          | 1          |
| <b>married</b>           | 4,290      | 0.654546    | 0.475572         | 0          | 1          |
| <b>seperated</b>         | 4,290      | 0.112354    | 0.315839         | 0          | 1          |
| <b>city</b>              | 4,290      | 0.332634    | 0.4712116        | 0          | 1          |
| <b>child1</b>            | 4,290      | 0.191842    | 0.393795         | 0          | 1          |
| <b>child2</b>            | 4,290      | 0.175058    | 0.380061         | 0          | 1          |
| <b>child36</b>           | 4,290      | 0.13007     | 0.33642          | 0          | 1          |
| <b>numberofhmmembers</b> | 4,290      | 4.032168    | 1.633152         | 1          | 11         |
| <b>childh</b>            | 4,290      | 0.807207    | 1.547799         | 0          | 13         |
| <b>elderh</b>            | 4,290      | 0.018331    | 0.260446         | 0          | 8.6        |
| <b>othermh</b>           | 4,290      | 0.053289    | 0.271812         | 0          | 6          |
| <b>childage02</b>        | 4,290      | 0.2351981   | 0.424172         | 0          | 1          |

*Хавсралт.6 Тоон өгөгдлийн шинж чанар / Гэр хороололд амьдардаг эмэгтэйчүүд /*

| <b>Variable</b>          | <b>Obs</b> | <b>Mean</b> | <b>Std. Dev.</b> | <b>Min</b> | <b>Max</b> |
|--------------------------|------------|-------------|------------------|------------|------------|
| <b>age</b>               | 3,499      | 38.31523    | 13.52113         | 15         | 64         |
| <b>age2</b>              | 3,499      | 1650.826    | 1061.186         | 225        | 4096       |
| <b>bachelor</b>          | 3,499      | 0.178337    | 0.382851         | 0          | 1          |
| <b>married</b>           | 3,499      | 0.656188    | 0.475047         | 0          | 1          |
| <b>seperated</b>         | 3,499      | 0.108317    | 0.310824         | 0          | 1          |
| <b>city</b>              | 3,499      | 0.262361    | 0.439981         | 0          | 1          |
| <b>numberofhmmembers</b> | 3,499      | 4.058588    | 1.672858         | 1          | 11         |
| <b>child1</b>            | 3,499      | 0.194627    | 0.39597          | 0          | 1          |
| <b>child2</b>            | 3,499      | 0.167191    | 0.373199         | 0          | 1          |
| <b>child36</b>           | 3,499      | 0.130037    | 0.336392         | 0          | 1          |

|                   |       |          |          |   |     |
|-------------------|-------|----------|----------|---|-----|
| <b>childh</b>     | 3,499 | 0.766759 | 1.491407 | 0 | 13  |
| <b>elderh</b>     | 3,499 | 0.018251 | 0.261606 | 0 | 8.6 |
| <b>othermh</b>    | 3,499 | 0.055286 | 0.288764 | 0 | 6   |
| <b>childage02</b> | 3,499 | 0.232066 | 0.422211 | 0 | 1   |

*Хавсралт.7 Тоон өгөгдлийн шинж чанар / Орон сууцанд амьдардаг эмэгтэйчүүд /*

| <b>Variable</b>          | <b>Obs</b> | <b>Mean</b> | <b>Std. Dev.</b> | <b>Min</b> | <b>Max</b> |
|--------------------------|------------|-------------|------------------|------------|------------|
| <b>age</b>               | 791        | 37.86473    | 13.05269         | 15         | 64         |
| <b>age2</b>              | 791        | 1603.895    | 1030.534         | 225        | 4096       |
| <b>bachelor</b>          | 791        | 0.561315    | 0.49654          | 0          | 1          |
| <b>married</b>           | 791        | 0.647282    | 0.478118         | 0          | 1          |
| <b>seperated</b>         | 791        | 0.130215    | 0.336753         | 0          | 1          |
| <b>city</b>              | 791        | 0.643489    | 0.479272         | 0          | 1          |
| <b>numberofhmmembers</b> | 791        | 3.915297    | 1.43964          | 1          | 9          |
| <b>child1</b>            | 791        | 0.17952     | 0.38403          | 0          | 1          |
| <b>child2</b>            | 791        | 0.209861    | 0.407467         | 0          | 1          |
| <b>child36</b>           | 791        | 0.130215    | 0.336753         | 0          | 1          |
| <b>childh</b>            | 791        | 0.986129    | 1.765869         | 0          | 11.25      |
| <b>elderh</b>            | 791        | 0.018682    | 0.255415         | 0          | 5.166667   |
| <b>othermh</b>           | 791        | 0.044459    | 0.17833          | 0          | 2.333333   |
| <b>child02</b>           | 791        | 0.249052    | 0.432738         | 0          | 1          |

*Хавсралт.8 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман регрессийн үр дүн*

| <b>Шугаман регресс</b>              | <b>Нийт</b>          |
|-------------------------------------|----------------------|
| <b>Нас</b>                          | 0.489*<br>(0.267)    |
| <b>Насны квадрат</b>                | -0.007**<br>(0.003)  |
| <b>Бакалавр</b>                     | -5.131***<br>(0.841) |
| <b>Гэрлэсэн</b>                     | -1.006<br>(1.375)    |
| <b>Салсан</b>                       | 0.615<br>(1.776)     |
| <b>Хот</b>                          | -1.981**<br>(0.842)  |
| <b>1 хүүхэдтэй хамт амьдардаг</b>   | -0.229<br>(1.074)    |
| <b>2 хүүхэдтэй хамт амьдардаг</b>   | -0.187<br>(1.232)    |
| <b>3-6 хүүхэдтэй хамт амьдардаг</b> | -1.766<br>(1.562)    |

|                                                                                    |                      |
|------------------------------------------------------------------------------------|----------------------|
| <b>Өрхийн ам бүлийн тоо</b>                                                        | 0.206<br>(0.303)     |
| <b>Хүүхэд асрахад зарцуулж буй хугацаа</b>                                         | -2.392***<br>(0.527) |
| <b>Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрахад зарцуулж буй хугацаа</b> | -0.527<br>(2.522)    |
| <b>Өрхийн бусад насанд хүрсэн гишүүдийг асрахад зарцуулж буй хугацаа</b>           | -1.281<br>(1.351)    |
| <b>0-2 насны хүүхэд</b>                                                            | -2.430**<br>(1.027)  |
| <b>Тогтмол утга</b>                                                                | 45.648<br>(4.984)    |
| <b>Ажиглалтын утга</b>                                                             | 2538                 |
| <b>Pseudo-R2</b>                                                                   | 0.056                |

Тэмдэглэгээ: ()стандарт алдаа. \*\*\*, \*\*, \* тус бүр 1%, 5%, 10%-ийн түвшинд ач холбогдолтой.

## ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН НОТОЛГОО

Энэхүү судалгааны ажил нь миний өөрийн бүтээл бөгөөд Монгол улсын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу бусдын оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй болохоо нотолж байна.

Ганбаатар овогтой Цэвээндолгор

.....

/гарын үсэг/